



САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2022.09.29 № 33

Татварын маргаан
шийдвэрлэлтийн талаар


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Татварын маргаан таслах зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрүүд (2016 оноос хойш өнөөдрийн байдлаар);
2. Татварын гомдол маргаан үүсгэсэн болон шийдвэрлэсэн байдал, шийдвэрлэхэд үндэслэл болгодог дүрэм журмууд;
3. 100 сая төгрөгөөс дээш дүнтэй татварын актууд, тэдгээрийн шийдвэрлэлт, хэрэгжилтийн байдлыг 2016 оноос хойш өнөөдрийн байдлаар дэлгэрэнгүйгээр;
4. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д тавьсан татварын акт, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх хуралдааны тэмдэглэлүүд болон гарсан шийдвэрүүд зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



Б.ЭНХБАЯР

2022000006